

**Хэрэглэх заавар: Эмчлүүлэгчидэд зориулсан мэдээлэл****НООФЕН 250 мг хатуу бүрээст**

Фенибутин

**Танд зориулсан чухал мэдээлэл агуулсан тул эмийн бэлдмэлийг хэрэглэхийн өмнө зааврыг сайтар уншина уу.**

- Зааврыг хадгал. Танд дахин унших хэрэг гарч болно.
- Хэрэв танд ямар нэг асуулт байвал эмч, эм зүйчээс лавлана уу.
- Энэ эмийг зөвхөн таньд зориулан жоронд бичсэн. Бусдад дамжуулж болохгүй. Хэдийгээр ижил шинж тэмдэг илэрсэн ч бусдад аюултай нөлөө үзүүлж болзошгүй.
- Хэрэв танд аль нэг гаж нөлөө илэрвэл эмч, эм зүйчид мэдэгдэнэ. Үүнд зааварт тусгагдаагүй гаж нөлөө байж болно. 4 хэсгийг үзин үү.

**Агуулга**

1. Ноофен гэж юу вэ, юунд хэрэглэх вэ
2. Ноофен хэрэглэхийн өмнө мэдвэл зохих зүйлс
3. Ноофен хэрхэн хэрэглэх вэ
4. Боломжит гаж нөлөө
5. Ноофен хэрхэн хадгалах вэ
6. Бусад мэдээлэл

**1. Ноофен гэж юу вэ, юунд хэрэглэх вэ**

Ноофен айdas түгшүүр бууруулах; нойрсолтыг сайжруулах; нистагм (нүдний хурдан, хэмнэлт хөдөлгөөн) далд үе, нистагмын үргэлжлэх хугацааг богиносгоно. Ноофен астениг мөн бууруулан (бие махбодын болон сэтгэцийн сурал, ерөнхий сурал), толгой өвдөх, толгой хүнд оргих, нойрны эмгэг, цочрол, сэтгэл хөдлөлийн өөрчлөлт (тогтвортгүй байдал) зэргийг арилгана. Ноофен сэтгэл хөдлөлийг нэмэгдүүлдэг.

Анхаарал, санах ой, сэтгэхүйн хурд, нарийвчлал зэргийг эмчилгээний үр дүнгээр сайжруулна. Астени, сэтгэлийн хөдөлгөөн буурсан өвчтөнд Ноофен нь хүний мэдрэмжийг сайжруулж, сонирхол, санаачлага, үйл ажиллагааны сэдэл сэргээх ба шаардлагагүй тайвшруулах нөлоө буюу сэтгэл хөдлөлийг бий болгодоггүй.

Ноофен эмийг:

- Астени болон сэтгэл түгшүүр нэмсэн мэдрэлийн эмгэгийн (сэтгэлийн түгшүүр айдас) эмчилгээнд; өндөр настанд – нойргүйдэл болон шөнийн түгшүүрийн эмчилгээнд; мэс заслын өмнөх сэтгэл зовнилоос урьдчилан сэргийлэлтэнд хэрэглэнэ.
- Хүүхдэд – ээрэх, хэл яриа гацах
- Миниере өвчин (дотор чихний эмгэг) Θөр өөр гарал шалтгаант хажуугийн аппаратын алдагдалтай холбоотой толгой эргэх
- Кинетозоос урьдчилан сэргийлэх (өвдөлт, бөөлжилт, судасны эмгэг зэрэг тодорхой бус байдал жишээ нь усан онгоц, онгоцоор явахад).
- Архины эмчилгээнд түр зуурын хам шинж үүсэхээс урьдчилан сэргийлэх тусламж үзүүлэх зорилгоор тус тус хэрэглэнэ.

## 2. Ноофен хэрэглэхийн өмнө мэдвэл зохих зүйлс

### Дараах нөхцөлд Ноофен хэрэглэхгүй вэ

- Хэрэв та фенибут болон найрлага дах бусад нэгдэлд харшилтай бол (6-р хэсэгт жагсаасан);
- Хэрэв та жирэмсэн, хөхүүл бол хориглоно.

### Анхааруулга, сээрэмжлүүлэг

Ноофен хэрэглэхийн өмнө эмч, эм зүйчтэй зөвлөлдөнө:

- Хэрэв та ходоод, дээрх гэдэсний шархлаатай бол эмчид заавал мэдэгдэнэ. Энэ нөхцөлд эмч танд тунг бууруулан өгнө.
- Мөн удаан хугацааны эмчилгээний үед эмч танд цусны шинжилгээ, элэгний үйл ажиллагааны шинжийг байнга хянах болно.

### Ноофен бусад эмийн харилцан нолоо

Хэрэв та ямар нэг эмийн бэлдмэл хэрэглэж буй бол уг эмийг хэрэглэхийн өмнө эмч, эм зүйчид заавал мэдэгдэх ёстой.

Ноофен эмийг бусад сэтгэц нөлөөт эмийн бэлдмэлтэй хамт хэрэглэх бол Ноофен эмийн тунг бууруулах шаардлагатай.

Ноофен гипнотик, наркозын, нейролептикууд, паркинсоны эсрэг эмүүдийн үйлчлэлийг удаашруулна.

## Жирэмсэн, хөхүүл

Хэрэв та жирэмсэн, хөхүүл бол, эсвэл жирэмсэн байх магадлалтай болон жирэмслэхээр төлөвлөж буй бол эмийг хэрэглэхийн өмнө эмч, эм зүйчтэй зөвлөлдөнө.

Ноофеныг жирэмсэний хугацаанд болон хөхүүл үед хэрэглэхийг хориглоно.

## Жолоо барих, механизмтай ажиллах

Төв мэдрэлийн системийн эмгэгийн үеийн эмийн эмчилгээнд өвчтөнд нойрмоглох шинж үүсэх тул болгоомжлох хэрэгтэй.

## Ноофен 180 мг лактоз агуулна

Хэрэв эмч танд зарим сахар үл тэвчилтэй гэж хэлсэн бол *ноофен* хэрэглэхийн өмнө эмчтэй зөвлөлдөх ёстой.

### 3. Ноофен хэрхэн хэрэглэх вэ

Ноофен эмийг эмчийн заавраар хэрэглэнэ. Хэрэв та итгэлгүй бол эмч, эм зүйчийн хамт шалгаж болно.

Бүрэсийг хоолны дараа хангалттай усаар даруулж ууна. Бүрэсийг зажлалгүй залгина.

*Астени, айдас түгшиүүр бууруулах:* насанд хүрэгчидэд – 250-500 мг тунгаар өдөрт 3 удаа.

Дангаар дээд тун 750 мг, 60-с дээш насны өвчтөнд -500 мг байна. Курс эмчилгээ 2-3 долоо хоног. Шаардлагатай бол 4-6 долоо хоног хүртэл үргэлжлүүлж болно.

*Миниере өвчин (дотор чихний эмгэг)* Θөр оор гарал шалтгаант хажуугийн аппаратын алдагдал: Миниере өвчин (дотор чихний эмгэг) Θөр өөр гарал шалтгаант хажуугийн аппаратын алдагдалтай холбоотой эмгэгт – 750 мг тунгаар өдөрт 3 удаа 5-7 өдөр, хажуугийн аппаратын эмгэгийн хүндрэл буурсан үед – 250-500 мг тунгаар өдорт 3 удаа 5-7 хоног, цааш 250мг тунгаар 5 өдөр хэрэглэнэ. Эмгэгийн хөнгөн хэлбэрийн үед – 250 мг тунгаар өдөрт хоёр удаа 5-7 хоног, цааш 250мг тунгаар өдөрт нэг удаа 7-10 хоног ууна. Гэмтлийн улмаас хажуугийн аппаратын алдагдалтай холбоотой толгой эргэхэд – 250 мг тунгаар өдөрт нэг удаа 12 өдөр хэрэглэнэ.

*Кинетозын урьдчилан сэргийлэлтэнд:* 250-500 мг тунгаар хүлээгдэж буй нэг цагийн өмнө, эсвэл кинетозын (толгой эргэх) эхний шинж тэмдэгийн эмчилгээнд хэрэглэнэ.

Шинж тэмдэг илэрвэл (бөөлжилт) үр дүн багатай байдаг.

*Арихины түр зуурын хам шинэсээс урьдчилан сэргийлэлтэнд:* эмчилгээний эхний өдөр - 250-500мг тунгаар өдөрт 3 удаа, 750 мг тунг унтахын өмнө; цааш тунг аажим бууруулна.

**MPL1.014.735/1.U**

Элэгний үйл ажиллагааны алдагдалтай овчтөнд: Ноофен өндөр тунгаар хэрэглэх нь элэг хордуулах нөлөө үзүүлнэ. Энэ бүлгийн өвчтөнд эмчилгээний үйлдэл үзүүлэх хамгийн бага тунгаар хэрэглэнэ.

Ноофены судалгааны үзүүлэлтэнд бөөрний эмсэгтэй овчтөнд эмийг эмчилгээний тунгаар хэрэглэхэд таагүй нөлөө үзүүлээгүй байна.

Эмэнд донтол, хараат, тэвчээргүй байдлын хам шинж үүссэгүй.

**Хүүхэд, освор насыханд хэрэглээ**

Ээрэх үед: 8 – 14 насанд – 250мг тунгаар өдөрт 3 удаа. Эмчилгээний үргэлжлэх хугацааг эмч тогтооно.

Хэрэв эм танд хэтэрхий хүчтэй, эсвэл сул нөлөө үзүүлж буй мэт санагдвал эмчтэй зөвлөлдөнө.

**Хэрэв та Ноофен эмийг хэтрүүлэн хэрэглэсэн бол**

Тунг хэтрүүлэн хэрэглэсэн нөхцөлд яаралтай эмч, эмнэлгийн тусlamж дуудах ёстой.

*Шинэс тэмдэг:* нойрмоглох, дотор муухайрах, бөөлжих, толгой эргэх

**Хэрэт та Ноофен эмийг хэрэглэхээ мартсан бол**

Эмчийн дааврын дагуу цаааш үргэлжлүүлэн хэрэглэнэ. Мартсан тунг давхарлан уухгүй.

**Хэрэв та Ноофен эмийн хэрэглээг зогсоосон бол**

Хэрэв танд эмийн талаар асуулт байвал эмч, эм зүйчээс лавлана уу.

**4. Боломжит гаж нөлөө**

Бүх эмийн адил байнга биш ч гаж нөлөө илэрч болно.

**Ховор (1000 хүнд 1-с олон)**

Харшлын урвалууд (тууралт, загатнаа).

*Тодорхойгүй (иэрэлийг тооцох боломжсгүй)*

Нойрмоглох, дотор муухайрах (эмчилгээний эхэнд);

Толгой өвдөх, толгой эргэх;

Элэг хордох (өндөр тунгаар удаан хугацаанд хэрэглэхэд).

Хэрэв танд ямар нэг гаж нөлөө илэрвэл эмч, эм зүйчид мэдэгдэнэ. Зааварт тусгагдаагүй гаж нөлөө байж болно.

**5. Ноофен хэрхэн хадгалах вэ**

25°C ихгүй хэмд хадгална. Гэрлийн тусгал, чийгнээс хамгаалан өөрийн саванд хадгална.

**MPL1.014.735/1.U**

Эмийг хүүхэд хүрэхгүй газарт хадгална.

Цаасан хайрцагт заасан хугацаа дууссан бэлдмэлийг хэрэглэхгүй.

Үүнд дуусах хугацааны сар, өдрийг бичсэн байна.

Үлдсэн хэсгийг ахуйн хог хаягдал, бохир усанд бүү устга. Удаан хугацаанд хэрэглээгүй эмийг хэрхэн устгах талаар эм зүйчээс асуу. Ингэснээр байгаль орчноо хамгаалахад туслах болно

**6. Бусад мэдээлэл****Ноофены найрлага**

- Идэвхтэй нэгдэл нь фенибут (Фенибут).

Ноофен хатуу бүрээс бүрд 250мг фнебут агуулна.

- бусад найрлагад 180 мг лактоз моногидрат, төмсний цардуул, кальцын стеарат.

Бүрэсийн найрлагад: желатин, титаны давхар исэл Е171.

**Дүрслэл, савлалт**

Хатуу цагаан №.0 бүрээсд цагаанаас цагаан бага зэрэг өтгөн өнгөт нунтаг агуулна.

Блистерт 10 бүрээс, 2 блистерийг (20 бүрээс) зааврын хамт цаасан хайрцагт савлана.

**Маркетингийн зөвшөөрөл эзэмшигч ба үйлдвэрлэгч**

JSC Olainfarm

Хаяг: 5, Rupnicu St., Olaine, LV-2114, Latvia.

Phone +371 67013701 • Fax +371 67013777

e-mail: olainfarm@olainfarm.lv